

БАТЛАВ

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ПҮРЭВДОРЖ**

**“НАРАНСЭВСТЭЙ- МАЗУНШАН” ХИЛИЙН БООМТЫГ СЭРГЭЭН НЭЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1 Хуульзүйн үндэслэл

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.1, 3.3.2.4, 3.3.2.8 дэх хэсгүүд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 28.1 заалтыг тус тус үндэслэн боловсруулсан болно.

1.2 Практик шаардлага

Өнгөрсөн онд Ганьсу муж нь Монгол Улстай ойролцоогоор 600.0 сая ам.долларын уул уурхайн бүтээгдэхүүний худалдан авалт хийж, 2024 онд 1.5-2.0 тэрбум ам.долларт төлөвлөсөн байна. Энэ нь Монгол, Хятад хоёр улсын худалдааны нийт эргэлтийн 10 орчим хувьтай тэнцэх үзүүлэлт юм. Түүхий эдийн худалдан авалт төдийгүй энэ салбарт хамтарч ажиллах, хөрөнгө оруулах, хамтарсан үйлдвэр байгуулах зэрэг ажлууд цаашид хийгдэх бүрэн боломж бий. Зөвхөн уул уурхай бус арав гаруй салбарт Хятадын хөрөнгө оруулалтыг татаж хамтарч ажиллах боломж байдаг. Гэвч хоёр талын худалдаанд төдийгүй бусад салбарын хатын ажилд тулгарч буй гол саад бол боомтын нэвтрүүлэх хүчин муу, боомтоос алслагдсан байдал юм.

Хятадын Мазуншан боомт Хятад-Монголын хилийн шугамын өмнө талд байрлах ба хоёр талын байнгын ажиллагаатай авто замын зорчигч болон ачаа тээврийн боомтыг нээж шаардлагатай бүтээн байгуулалтыг хийхээр зорьж байна. Эхний ээлжинд ачаа эргэлтийн хэмжээг жилд 30 сая тонн хүргэж, нийт 200.000 хүн, 600.000 автомашин нэвтрүүлэх хүчин чадалтай байхаар тооцоолжээ.

“Нарансэвэстэй-Манзушан” боомтыг нээснээр БНХАУ-тай хийж буй худалдааны эргэлт нэмэгдэх, хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх, хил орчмын аялал жуулчлал хөгжих, сэргээгдэх эрчим хүчний хамтын ажиллагаа сайжрах, химийн аюултай барааг бүтээгдэхүүний импортыг шийдвэрлэх, газрын тос, дизель түлшний худалдааг өргөжүүлэх, Говь-Алтай, Баянхонгор, Завхан аймаг дахь уул уурхай,

хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зах зээлийн эргэлтэд орох, баруун бүсийг жимс, жимсгэнээр хангах, Хятадын төвийн мужтай дэд бүтцээр холбогдох, Орос-Монгол-Хятад чиглэлийн ачаа тээвэр нэвтрэх, орон нутаг хоорондын харилцаа, хүмүүнлэгийн солилцоо гүнзгийрэх зэрэг боломжууд нээгдэнэ. Хятадын талаас тус боомтоос Говь-Алтай аймаг хүртэл хатуу хучилттай авто зам болон төмөр зам тавьж өгөх, Баянхонгор аймаг хүртэл хатуу хучилттай зам барьж өгөх боломжтой.

Энэ боомтын давуу тал нь Халхын баруун өмнөдийн овооноос хойшоо Орос, Хятадын хил хүртэл Шинжаань Уйгарын Өөртөө Засах Оронтой, зүүн тийш Төв хятад болон Өвөрмонгол, Шинжаань Уйгарын орны дунд 60 км хүзүүвч байдаг Ганьсу мужтай хиллэдэг боомт юм. Тэр хүзүүвчээр төв хятадтай холбогдох боломжтой ганц боомт бол Нарансэвстэй юм. Алтай сум хүртэлх 500 км үргэлжлэх дэд бүтцийг бүтээн босгоход шаардлагатай санхүүжилт болон засмал замыг барьж байгуулахад Хятадын Ганьсу муж өөрийн хөрөнгөөр туслах, бүрэн хариуцан хүлээлгэн өгөх боломжтой гэдгээ илэрхийлсэн.

Ганьсу мужид хүчин чадал өндөр боловсруулах үйлдвэртэй, химийн үйлдвэр сайн хөгжсөн, газрын тосны нөөц арвинтай, шинэ эрчим хүчний үйлдвэр өндөр түвшинд хөгжсөн, нар, салхины нөөц сайтай, Ланьжөү-Өрөмч-Төв Ази-Европ, Дандун-Хоргос чиглэлийн авто зам, төмөр замын сүлжээнд холбогдсон, тээвэр логистикийн зангилаа, Мазуншан боомтын хатуу, зөөлөн дэд бүтэц, харилцаа холбоо, ус, хөгжлийн төлөвлөгөө бүрэн шийдэгдсэн, мужийн зүгээс боомтыг нээх хүсэл эрмэлзэлтэй, монголын талын боомтын дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийхэд бэлэн байгаа юм.

Мазуншан боомт нь хоёр улсын 4 муж, аймгийн хил залгаа бүсийн төвд оршдог. Тус боомт нь Евроазийн эх газрын гүүр стратегийн гарц, баруун өмнөд болон баруун бүс нутгийн улс орнуудын зам тээврийн стратегийн уулзвар бүс, Торгоны замын эдийн засгийн коридор болон Тал нутгийн Торгоны замын чухал зангилаа цэг болдог газар нутгийн давуу талтай бүхий боомт юм. Мазуншан боомтыг сэргээн нээснээр Ганьсу мужаас хэрэгжүүлж буй гадагшаа нээлттэй бодлого болон “Нэг бүс-нэг зам” уриалга болон “Баруун бүс нутгийн хуурай болон далайн шинэ гарц” бүтээн байгуулалтад чухал ач холбогдолтой байх юм.

Ганьсу муж нь 2,322 км төмөр зам, 35.9 мянган км авто замын сүлжээтэй бөгөөд “Гурван хэмжээст тээврийн сүлжээний төлөвлөгөө”-нд (2022.09.27-ны өдөр баталсан) тусгаснаар 2035 он гэхэд 9,000 км төмөр зам (хурдны болон ачаа, тээврийн-2), 38,000 орчим автозам (хурдны 2 эгнээ, энгийн 6 эгнээ) барихаас гадна мужийн хойд боомтуудыг холбосон тээврийн сүлжээ барих замаар гуравдагч улсад нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Нарансэвстэй-Мазуншан” хилийн боомтыг сэргээн нээх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 3 зүйлтэй байх бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгасан болно. Үүнд:

1 дүгээр зүйлд: Монгол, Хятад улсын 496-р хилийн баганын чиглэлээр хоёр талын зорчигч, ачаа тээврийн "Нарансэвстэй- Мазуншан" байнгын ажиллагаатай авто замын боомтыг 2025 оны 1 дүгээр сарын 1 өдрөөс сэргээн ажиллуулах;

- 2 дугаар зүйлд: Говийн Их Дархан Цаазат газар “А” хэсэгт ашигт малтмалын ямар нэгэн үйл ажиллагаа явуулахыг хориглох,
- 3 дугаар зүйлд: Боомтыг шинээр барих, бусад шаардагдах хөрөнгө оруулалтын ажлыг төсөвт дарамт учруулахгүйгээр гадаадын хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн хөрөнгөөр шийдвэрлэх, Алтай сумаас Нарансэвстэй боомт хүртэлх хатуу хучилттай замын бүтээн байгуулалтыг Говийн Их Дархан Цаазат газрыг тойруулж тавих.
- 4 дүгээр зүйлд: “Нарансэвстэй-Мазуншан” хилийн боомтыг сэргээн нээх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгжилтэд хяналт тавих талаар тус тус тусгасан.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

“Нарансэвстэй-Мазуншан” хилийн боомтыг сэргээн нээх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна:

1. Евроазийн эх газрын гүүр стратегийн гарц, баруун өмнөд болон баруун бүс нутгийн улс орнуудын зам тээврийн стратегийн уулзвар бүс, Торгоны замын эдийн засгийн коридор болон Тал нутгийн Торгоны замын чухал зангилаа цэгтэй холбогдох боломж гарч ирнэ.
2. Далайд гарцгүй Монгол Улсын хувьд хөрш орнууддаа, цаашлаад тэдгээрээр дамжин далайд хүрч гуравдагч улсуудад бараа, бүтээгдэхүүнээ ашигтай нөхцөлөөр экспортлох боломжтой
3. Шинэ эрчим хүчний салбар. УЦС, нар, салхи, сэргээгдэх эрчим хүчний талаар хамтарч ажиллах боломжтой. Энэ чиглэлээр сургалт зохион байгуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, Монгол улсад хөрөнгө оруулалт хийх мөн салбар үйлдвэр байгуулж хамтарч ажиллах боломжтой болно.
4. Өнгөт металлын үйлдвэрийн салбар. Зэс, алт, төмрийн хүдэр боловсруулах чиглэлээр манай улсад хөрөнгө оруулалт хийж, анхан болон дунд шатны боловсруулах үйлдвэр байгуулах боломж нээгдэнэ.
5. ХАА салбар. Нарийн ногооны хүлэмжийн салбарт хөрөнгө оруулалт хийх, энэ чиглэлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх, жимс, жимсгэнэ, ХАА-н тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалт зохион байгуулах, боловсон хүчин бэлтгэхэд туслах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэргээр хамтарч ажиллах боломжтой болно.
6. Уул уурхайн салбар. Монгол Улсад нүүрс, цайр, жонш, төмрийн хүдрийн анхан болон дараах шатны мөн гүйцэт боловсруулах үйлдвэр байгуулах чиглэлд хамтарч ажиллах боломжтой.

7. Аялал жуулчлалын салбар. Хил орчмын болон соёл, байгалийн цогцолбор газартай танилцах аялал жуулчлалыг хөгжүүлж, Ганьсу мужаас Монгол улс чиглэлийн шууд нислэг үйлдэх боломж бий болно.
8. Цөлжилт, шар шороон шуургатай тэмцэх чиглэлээр. Говийн их дархан цаазат газрын “А” хэсэг нь Төв Азийн хэт гандуу, эрс тэс уур амьсгалтай, цөлийн бүсэд хамаарах ба энд ил задгай ус ховор, ургамлан бүрхэвч сийрэг, ядмаг, хүн, мал нутаглахад тохиромжгүй зэлүүд нутаг юм. Монгол улсын Ерөнхийлөгч У. Хүрэлсүхийн санаачилсан тэрбум мод төслийн хүрээнд хоёр улсын Засгийн газар хамтран Улаанбаатар хотод судалгааны төвийн дэргэд цөлжилт, шар шороон шуургыг судлах лаборатори байгуулах, манай талын боловсон хүчинд сургалт, туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах, мод, ургамал тарих, Монгол улсад шаардлагатай ургамлын үрслэгээ хийх зэргээр хамтран ажиллах боломж нээгдэнэ. БНХАУ дарга Ши Жиньпин, Монгол Улсын Ерөнхийлөгч У. Хүрэлсүх нарын уулзалтын үеэр “1.0 тэрбум мод тарих” санаачилгыг дэмжихээ Хятадын тал илэрхийлсэн. Иймээс Ганьсу мужид байрлах БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академийн “Баруун Хойд экологийн орчны нөөц судлалын хүрээлэн”-тэй хамтарч ажиллах боломжтой.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

“Нарансэвстэй-Мазуншан” хилийн боомтыг сэргээн нээх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиуд, Улсын Их Хурлын холбогдох тогтоолуудтай нийцсэн болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын хуулиуд болон Улсын Их хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт орохгүй болно.